

Төслийн нэр, дугаар: “Ирээдүйд үлдэх баялаг”				
Хэрэгжүүлэгч байгууллагын нэр: “Хэнтий аймгийн Ажил Олгогч Эздийн холбоо”				
Тайлан хамрах хугацаа	1-р санхүүжилт	2-р санхүүжилт	3-р санхүүжилт	Эцсийн /Нэгдсэн/тайлан
2016/07/19 – 2016/09/30	Хугацаа 2016/07/19 3513650 төг	Хугацаа 2016/11/10 1308460 төг	Хугацаа	Хугацаа 2016/12/15

ТОВЧИЛСОН ҮГС

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн үндсэн зорилго: Хэнтий аймгийн Баян-овоо сумын захиргаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу Ханшашир ХХК-тай байгуулсан Хамтран ажиллах гэрээнд мониторинг хийх, замаар талуудын хүлээсэн үүргийн бодит хэрэгжилт, зөрчил, түүний нөхцөл, шалтгааныг тодорхойлж, олон нийтэд мэдээлж, нөлөөлөл хийснээр гэрээний хэрэгжилт үр нөлөөг сайжруулахад хувь нэмэр оруулахад энэхүү төслийн үндсэн зорилго оршино

1.2 Төслийн зорилтууд

Мониторингийн дээрх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний эрх зүйн орчин, Хэнтий аймгийн Баян-овоо сумын захиргаанаас Ханшашир ХХК-тай байгуулсан Хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилттэй холбоотой баримт мэдээллийг цуглуулах замаар гэрээний тодорхой зүйл заалтыг сонгож авах
- Мониторингийн хүрээнд сонгон авсан гэрээний тодорхой заалтын хэрэгжилтийг үнэлж, ололт амжилт, зөрчил дутагдал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг баримтжуулах:
- Гэрээний хэрэгжилтэд саад учруулж байгаа нөхцөл шалтгааныг арилгахад чиглэсэн дүгнэлт зөвлөмж гаргаж, гэрээний талууд болон олон нийтэд хүргэх замаар гэрээ, түүний хэрэгжилт үр нөлөөг сайжруулах нөлөөлөл хийх.

- Орон нутагт хандив тусламж үзүүлэх үүргийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжилтийг бууруулахад сөрөг нөлөө үзүүлж буй шалтгаан, саад бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгах арга замын талаар зөвлөмж гаргах

1.3 Хүлээж буй үр дүн

- Мониторингийн хүрээнд сонгон авсан орон нутгийн гэрээний хэрэгжилтийн бодит байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байна.
- Гэрээ, түүний хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой тодорхой санал зөвлөмж гарсан байна.
- Мониторингийн хүрээнд гарсан санал дүгнэлтийг орон нутгийн иргэд болон гэрээний талуудад хүргэх нөлөөллийн үйл ажиллагаа хийснээр гэрээний чанар, үр нөлөө, хэрэгжилт сайжирсан байна.
- Олон нийтийн орон нутгийн гэрээний тухай ойлголт, мэдлэг сайжирснаар гэрээний хэрэгжилтийг шаардах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг хянах үйл явцад оролцох хяналт оролцоо нэмэгдсэн байна.

1.4 Төслийн хамрах хүрээ

Мониторингийн төсөл нь 2016 оны 07 сараас 2016 оны 12 сарыг дуустал нийт 6 сарын хугацаанд хэрэгжсэн болно. Мониторингийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-овоо сумын захиргаанаас Ханшашир ХХК-тай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу байгуулсан Хамтран ажиллах гэрээний дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутагт хандив дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үүргүүдийн хэрэгжилтийг авч үзлээ. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр буюу 2015 оны 06 сараас мониторингийн төсөл хэрэгжсэн хугацаа буюу 2016 оны 12 сар хүртэлх хугацаанд гэрээний талуудаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хамран хийгдлээ. Байршлын хувьд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ, нөлөөлөл хийх ажлууд нь төслийн багийн оршин байх Хэнтий аймаг, тэр дундаа Баян-овоо сум, түүний Наран багт төвлөрөн хийгдсэн болно. Төслийн судалгаа, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд Хэнтий аймаг, Баян-овоо сумын холбогдох албан тушаалтан, иргэд, төдийгүй Ханшашир ХХК-ийн ажилтан, албан хаагчид оролцлоо.

1.5 мониторингийн аргачлал

Мониторингийн аргачлалыг Нээлттэй нийгэм форумын сургалт, арга зүй, бусад ТББ – уудын мониторингийн туршлагыг агуулсан гарын авлага, чадавхад үндэслэн хийсэн.

- Судалгааг санал асуулгын болон ярилцлагын аргыг ашиглан сумын иргэд, болон уурхайн ажилчдыг хамруулан хийв. Үүнд орон иргэд 30, уурхайн ажилчид 30, нийт 60 хүн хамрагдав. Судалгаанд хамрагдсан иргэд нь наран

багийн малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, төрийн албан хаагчдаас бүрдэв.



- Фото зураг, баримт бичгийн хуулбар авах болон ярилцлага, асуулгын үеэр тэмдэглэл хөтлөх замаар баримтжуулалт хийж ажилласан.
- Баримт бичгийг судлах аргын хүрээнд холбогдох хууль тогтоомж, талуудын хооронд байгуулагдсан Хамтын ажиллагааны гэрээ, Баян – Овоо сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Х.Гэрэлмаагаас авсан Ханшашир ХХК – тай холбоотой бичиг баримт, Баян – Овоо сумын ИТХ, “Олон талт зөвлөл” – ийн хамтарсан ажлын хэсгийн илтгэх хуудсуудыг хамруулан судаллаа.
- Түүнчлэн ОҮИТБС – ын цахим мэдээллийн сангаас компанийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, хандив тусламжийн дүнг авч бусад баримт бичигтэй харьцуулан үзлээ.

1.6 Мониторингийн баг

Мониторингийг хэрэгжүүлэгч Хэнтий аймгийн Ажил олгогч эздийн холбоо (АОЭХ) нь анх 1992 онд Хэнтий аймгийн хувийн Үйлдвэрийн эздийн холбоо нэртэйгээр байгуулагдсан. Өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, төрийн бус байгууллага. Анх 12 гишүүнтэй байсан бол одоо 70 гаруй гишүүн, дэмжигчидтэй.

Аймгийн АОЭХ нь орон тооны бус 2 ажилтантай бөгөөд холбооны тэргүүн, нарийн бичиг буюу менежер, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсөлд АОЭХ-ны Т.Эрдэнэбаатар нь удирдагчаар, менежер Д.Аззаяа, “Хос Аз Жаргал” ТББ-ын гишүүн Д.Эрдэнэсаруул нар төслийн багийн гишүүнээр тус тус ажиллав. Төслийн удирдагч нь сум орон нутаг, Ханшашир ХХК-ын удирдлагууд, орон нутгийн иргэдтэй уулзах, баримт материал дээр ажиллан дүгнэлт гаргах ажлуудыг хариуцан гүйцэтгэсэн бол Д.Аззаяа, Д.Эрдэнэсаруул нар нь суурь судалгаа, эрх зүйн баримт бичгийн судалгаа, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлуудыг хийсэн.

ХОЁР. ҮНДСЭН ТАЙЛАН

Ханшашир ХХК болон түүний орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээний тухай мэдээлэл

Ханшашир ХХК нь 2007 оны 5 – р сарын 29-нд гадаад худалдаа, ашигт малтмалын хайгуул хийх чиглэлээр байгуулагдаж, 2011 онд Дожирийн хайлуур жоншны ордын хайгуулын ажлыг эхэлж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Улмаар 2013 онд MV016819 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авч, Хэнтий аймгийн Баян-овоо сумын Наран багийн нутаг Дожир гэдэг газарт 2014 оноос эхлэн хайлуур жоншны хүдэр олборлох үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Дожирын хайлуур жоншны орд нь 31600 тонн ашиглалтын нөөцтэй бөгөөд 20 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна. Жилд 1600 тонн хайлуур жоншийг гүний уурхайн аргаар олборлох хүчин чадалтай.

Тус компани 2015 оны 06 сарын 02-ны өдөр Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Хэнтий аймгийн Баян-овоо сумын Засаг даргатай, Хамтран ажиллах гэрээг 2 жилийн хугацаатайгаар байгуулсан. Энэхүү гэрээ нь нийт 5 зүйлтэй бөгөөд гэрээний зорилго, талуудын үүрэг хариуцлага, гэрээний хугацаа, түүнийг сунгах, гэрээ дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх зэрэг асуудлуудыг зохицуулжээ.

Гэрээний хэрэгжилтэд Баян-овоо сумын “Олон талт зөвлөл” хяналт тавьж ажилладаг. Олон талт зөвлөл нь сумын ИТХ – ын 2014 оны 6 – р сарын 17 – ны өдрийн 20 тоот тогтоолоор байгуулагдсан 11 хүний бүрэлдэхүүнтэй. Зорилго: Байгалийн нөөцийн зүй зохистой хариуцлагатай ашиглалтыг бий болгож, түүний үр өгөөжийг тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлэх, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалахад талуудын идэвхтэй бүтээлч оролцоог бий болгох. Тус зөвлөлөөс уурхайн үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 2014 оны 6 ба 7 дугаар сар, 2016 оны 6 сард тус тус хяналт шалгалт хийжээ. Үүний үр дүнд ажилчдын ажиллах, амрах орчин сайжирсан байна.

Байгаль орчныг хамгаалах үүргийн хэрэгжилтийг үнэлэх

Нутгийн захиргааны байгууллагын үүргийн хэрэгжилт

Сумын нөхөн сэргээлтийн санд жил бүр байгаль хамгаалах ажилд зарцуулах хөрөнгийг шилжүүлэхийг шаардах, шилжүүлээгүй тохиолдолд тухайн жилийн олборлолтын үйл ажиллагааг зогсоох. (Хамтран ажиллах гэрээний 2.4 дүгээр заалт)

- Компанийн ОУИТБС-ын тайланд дурдсанаар 2015 онд 6 617 000 төгрөгийн барьцаа хөрөнгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулсан байна.¹ Харин гэрээнд заасан ёсоор Сумын нөхөн сэргээлтийн санд мөнгөн хөрөнгө байршуулаагүй боловч энэ талаар нутгийн захиргааны байгууллагын зүгээс ямар нэгэн шаардлага тавьж,

¹ <http://e-reporting.eitimongolia.mn/preportShow/2015/3322/0/50179>, ОУИТБС-ын тайлангийн систем дэх Ханшашир ХХК-ний 2015 оны тайлан

арга хэмжээ авч байгаагүй ажээ.

- Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн² дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг сумын тусгай дансанд байршуулах, харин ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулах үүрэгтэй байдагтай холбоотой юм. Иймээс ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ханшашир ХХК нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу суманд бус Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны (хуучин нэрээр) тусгай дансанд байршуулах хуулийн үүргээ хэрэгжүүлсэн ч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй мэт харагдах байдал үүсжээ.
- Дээрхээс харахад гэрээний 2.4 дүгээр зүйл нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн байна, хэрэгжих боломжгүй зохицуулалт болжээ. Иймд талууд цаашид гэрээ байгуулахдаа уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой нийцүүлэхэд анхаарч, зохих мэргэжилтний туслалцааг авч байх нь зүйтэй байна.

Уурхайн эдэлбэр газрын орчны бохирдолд байнгын хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах (Хамтран ажиллах гэрээний 2.9 дүгээр зүйл)

- Баян-Овоо сум нь Олон талт зөвлөлийг байгуулан уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьж ирсэн байна. Энэ хүрээнд 2016 онд Ханшашир ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаад ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргажээ. Гэхдээ Ханшашир ХХК-ийн үйл ажиллагаанд нийт 3 шалгалт хийсний 2 нь 2014 онд, 1 нь 2016 хийгдсэн ба гэрээ байгуулсан жил буюу 2015 онд шалгалт хийсэн тухай баримт байхгүй байгаагаас харвал тогтмол хяналт тавих үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Уурхайн орчны тээвэрлэлтийн замыг сайжруулан засах шаардлага тавих (Хамтран ажиллах гэрээний 2.6 дүгээр зүйл)

- Ханшашир ХХК нь олборлосон бүтээгдэхүүнээ Багануур хүртэл 330 км зайд орон нутгийн замаар тээвэрлэсээр байгаа боловч замыг хэрхэн засаж сайжруулсан талаар бодитой мэдээлэл байхгүй байна. Тээвэрлэлтийн замд намагтай шавар ихтэй газарт шороо хайрга хийж тэгшилдэг гэдгээ компанийн зүгээс мэдэгдэж байгаа ч энэ нь тоосжилт үүсэх, хөрсний элэгдлийг бууруулахад төдийлөн ач холбогдолгүй байна. Гэтэл замыг засаж сайжруулах талаар орон нутгийн захиргаанаас өнөөг хүртэл компанид ямар нэгэн шаардлага гаргаж байгаагүй байна.
- Нөгөө талаар замыг засаж сайжруулах гэдэгт яг юуг ойлгох талаар гэрээнд тодорхой бус байгаа нь энэхүү үүргийн хэрэгжилтийг үнэлэхэд бэрхшээл учруулж байна.

Ханшашир ХХК-ийн үүргийн хэрэгжилт

Сумын нөхөн сэргээлтийн санд жил бүр мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх (Хамтран ажиллах гэрээний 3.11 дүгээр зүйл)

² Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэг

- Хамтран ажиллах гэрээний 2.4 дүгээр заалтын талаар дээр дурдсан дүгнэлтийг харна уу.

Орон нутагтай ус ашиглах, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах (Хамтран ажиллах гэрээний 3.13 дугаар зүйл)

- Ханшашир ХХК нь Хамтран ажиллах гэрээний дагуу 2013 оны 01 сарын 10-ны өдөр Баян-овоо сумын Засаг даргатай Хог хаягдал тээвэрлэх тухай гэрээ байгуулан ажиллаж байна. (Хавсралт-2)
- Ханшашир ХХК нь Усны тухай хууль болон Хамтран ажиллах гэрээний дагуу Ус ашиглах гэрээг 2015, 2016 онд Баян-овоо сумын захиргаатай байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу 2015 онд ус ашигласны төлбөрт нийт 3 525 300 төгрөгийг төлсөн байна. Харин 2016 оны ус ашиглалын төлбөрийн тайлан хараахан гараагүй болно. (Хавсралт-12)
- Түүнчлэн усны нөөцийг зохистой ашиглах буюу гадаргын усыг хуримтлуулан үйлдвэрлэлд ашиглах зорилгоор уурхайн гүний усны ашиглалтын цэгт тоолуур тавьж олборлолтод ашигласан гүний усыг үйлдвэрлэлд дахин ашиглаж байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө багатай бөгөөд бусад уурхайнуудад үлгэр жишээ үзүүлэх тэргүүн туршлага болж байна. (Хавсралт-13)
- Гэхдээ Ус ашиглах тухай гэрээг төрийн холбогдох байгууллагатай байгуулан мөрдөж ажиллах нь Монгол улсын нутаг дэвсгэрт ус ашиглаж байгаа иргэн, аж ахуй нэгж бүрийн хуулиар хүлээсэн үүрэг билээ.³ Иймд нэгэнт хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүргийг Хамтран ажиллах гэрээнд тусгах нь төдийлөн ач холбогдолтой бус юм

Ажлын байр нэмэгдүүлэх үүргийн хэрэгжилт

Нутгийн захиргааны байгууллагын үүргийн хэрэгжилт

Уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардагдах ажиллах хүчээр хангах, мэргэжлийн сургалтанд хамтран хамруулах (Хамтран ажиллах гэрээний 2.1 дүгээр зүйл)

- Гэрээний дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд талууд хэрхэн хамтран ажилласан талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Харин 2016 оны 4 сард Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Ханшашир ХХК-тай Хамтран ажиллах гэрээг байгуулж, Хэнтий аймгийн Чингис хот, Бор-Өндөр сум, Баян-овоо сумдаас ажиллах хүчин авах тухай тохиролцжээ. Уг гэрээгээр Ханшашир ХХК нь Хөдөлмөрийн хэлтэст Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтын дагуу оны эхэнд нийт ажлын байрны мэдээг, улирал тутам шинэ ажлын байрны мэдээг, сул чөлөөтэй ажлын байрны мэдээг тухай бүрд өгч ажиллах үүрэг хүлээсэн боловч биелэлт хангалтгүй байна.⁴

Мэргэжилтэй боловсон хүчнээр хангах боломжгүй тохиолдолд уурхайн захиргаатай тохиролцон гэрээгээр мэргэжилтэн бэлтгүүлэхийг уурхайн удирдлагаас шаардах. (Хамтран ажиллах гэрээний 2.2 дугаар зүйл)

³ Усны тухай хуулийн 29 дүгээр зүйл.

⁴ 2016 онд Хөдөлмөрийн хэлтэс болон Ханшашир ХХК-ын хооронд байгуулсан Хамтран ажиллах гэрээ (Хавсралт-15), 2016 оны 4 сарын 28-ны өдөр Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргатай хийсэн ярилцлага.

- Хамтран ажиллах гэрээ байгуулснаас хойш 2016 онд Баян-Овоо сумаас нийт 29 ажилтан авч ажиллуулжээ. Мөн Хэнтий аймгийн Бэрх тосгон, Бор-Өндөр сумаас өмнө нь уурхайд ажиллаж байсан туршлагатай ажилчид ирж ажилладаг байна. Нутгийн иргэдийг ажлын байраар хангахдаа эхлээд дадлагажигчаар ажиллуулж, дараа нь өрөмдөгч, олборлогч, лифтчин зэрэг үндсэн ажилд шилжүүлэн авдаг байна.

Ийнхүү Баян-Овоо сумаас авч ажиллуулсан ажилтны тоо хязгаартай бөгөөд бусад орон нутгаас ажилтан авч ажиллуулсаар атал нутгийн захиргааны гэрээнд заасны дагуу орон нутгийн иргэдийг сургалтад хамруулж, мэргэжил эзэмшүүлэх шаардлагыг уурхайд хандан гаргаж байгаагүй ажээ.

Гадаадын ажилчны тоог тогтоосон квотоос илүү ажиллуулсан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу зохих төлбөрийг сумын төсөвт төвлөрүүлэхийг шаардах (Хамтран ажиллах гэрээний 2.3 дугаар зүйл)

- “Ханшашир” ХХК нь Хөдөлмөрийн сайдын 2016 оны 3 сарын 3-ны өдрийн А55 тушаалаар олгогдсон зөвшөөрлийн дагуу БНХАУ-ын 45 иргэнийг ажиллуулж байгаа бөгөөд үүнээс зөвхөн 13 иргэн нь Хэнтий аймгийн Баян-овоо суманд ажиллажээ.⁵ (Хавсралт-3) Иймд сумын хөдөлмөр эрхлэлтийн санд гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр хийх шаардлага үүсээгүй байна. Өөрөөр хэлбэл Ханшашир ХХК-ны гадаад ажилтны тоо нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй тул сумын удирдлагаас гэрээнд заасны дагуу шаардлага тавих нөхцөл үүсээгүй байна. Харин ОУИТБС-ын цахим тайлангийн системд дурдсанаар Ханшашир ХХК нь 2015 гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрт 24 947 200 төг төвлөрүүлсэн байх боловч тухайн жилд хэдэн гадаадын ажилтан ажиллуулах зөвшөөрөл авсан тухай Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хийсэн гэрээ байхгүй байна. Харин 20 гадаад иргэн ажиллаж байсан гэж сумын БОХУ байцаагч Х.Гэрэлмаагаас мэдээлэл авав.

Уурхайд ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын төлбөрийг төлүүлэх (Хамтран ажиллах гэрээний 2.5 дугаар зүйл)

- Ханшашир ХХК нь өмнө нь ажилтны эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг харьяаллын дагуу Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст төлдөг байсан бол 2016 оны 08 сараас эхлэн Хэнтий аймгийн Баян-овоо сумын Нийгмийн даатгалын хэлтэст төвлөрүүлж байхаар болсон. Энэ үеэс хойш буюу 8, 9, 10 – р саруудын нийт 66 хүний 14,5 сая/төг – ийн НДШ төлсөн байна.
- Ханшашир ХХК-ны мэдээлснээр 2016 оны байдлаар Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын санд 14 000 000 орчим төгрөгийг төвлөрүүлээд байна.
- Нөгөө талаар ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх нь аж ахуй нэгжийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүргийн нэг мөн⁶ тул орон нутгийн Хамтран ажиллах ажиллах гэрээнд тусгах нь төдийлөн ач

⁵ Хэнтий аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2016 оны 10 сарын 21-ны өдрийн 30 тоот албан бичиг, Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын Хэнтий аймаг дахь төлөөлөл 2016 оны 10 сарын 24-ны өдрийн албан бичиг

⁶ Хөдөлмөрийн тухай хууль 46 дугаар зүйл.

холбогдолтой бус юм. Учир нь гэрээнд тусгаагүй байсан ч хуулийн дагуу биелүүлэх үүрэг билээ.

“Ханшашир” ХХК-ийн үүргийн хэрэгжилт

Орон нутгаас 300–400 ажиллах хүчээр хангахыг шаардах, мэргэжилтэй боловсон хүчнийг хамтран бэлтгэх. (Хамтран ажиллах гэрээний 3.2 дугаар зүйл)

- Гэрээн дээрх заалтыг харахад Ханшашир ХХК-д орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх талаар тодорхой үүрэг хүлээгээгүй, харин ажиллах хүчээр хангахыг шаардах эрхийг олгожээ.
- Нөгөө талаар 2015-2016 он буюу мониторингийн судалгааны хамрах хугацаанд тус уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй тул 300-400 хүнийг ажиллуулах боломжгүй байсан ба 2015-2016 онд нийт давхардсан тоогоор 260 хүн ажилласны 80 орчим нь л орон нутгийн иргэд байжээ. (Хавсралт-4) Ийнхүү уурхайн нийт ажилтны дөнгөж 30 орчим хувийг орон нутгийн иргэд эзэлж байгаа нь орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүй байгаагаас шалтгаалжээ.
- Гэрээг анх байгуулахдаа уурхайн хүчин чадал, ТЭЗҮ-д тусгасан ажлын байрны тоо зэргийг харгалзан үзээгүйгээс ийнхүү анхнаасаа хэрэгжих боломжгүй заалтыг тусгасан нь ийнхүү гэрээ хэрэгжээгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна

Ажилчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэндийн даатгалд, нийгмийн даатгалд хамруулах. (Хамтран ажиллах гэрээний 3.10 дугаар зүйл)

- Хамтран ажиллах гэрээний 2.5 дугаар зүйлтэй холбоотой дүгнэлтийг үзнэ үү.

Орон нутагт хандив тусламж үзүүлэх үүргийн хэрэгжилт

“Ханшашир” ХХК-ийн хүлээх үүрэг

Сумын хэмжээнд байгалийн аюулт үзэгдэл тохиолдсон үед тусламж хүсэх. (Хамтран ажиллах гэрээний 4.1 дүгээр зүйл)

- Компани гэрээний дээрх үүргийн дагуу 2015 онд малын халдварт өвчний улмаас үхсэн малын сэг зэмийг устгах, 2016 оны зуны аадар борооны улмаас үүссэн үерийн үед хамгаалах далан барих, өвлийн бэлтгэлийг хангахтай холбогдуулан сумын төсвийн байгууллагуудад нүүрс татахад машин техникийн туслалцаа үзүүлжээ. (Хавсралт-10)
- Хандив туслалцаа үзүүлэхдээ 2 тал албан ёсоор хүсэлт тавьж, дээрх ажлуудыг хэрэгжүүлэхэд 4550,0 мян/төг зарцуулжээ.
- Түүнчлэн нэг иргэнд гэр олгожээ.

ГУРАВ. ГАРСАН ҮР ДҮН

Энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүлснээр төслийн багийн гишүүд уул уурхайн үйл ажиллагаа, тэр дундаа орон нутгийн хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийн талаар мэдлэг хуримтлуулж, энэ төрлийн гэрээний үйл ажиллагаанд мониторинг хийх арга зүй, мэдээллийн олон төрлийн эх сурвалжид үндэслэн дүн шинжилгээ хийх, нөлөөллийн баримт бичиг боловсруулах чадавх эзэмшлээ.

Түүнчлэн орон нутгийн хөгжил, ажлын байр, байгаль орчин зэрэг тэдний нийтлэг эрх ашигтай шууд холбоотой Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний талаар Баян-Овоо сумын иргэд тодорхой мэдлэгтэй болсон нь цаашид гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлага гаргах, гэрээ байгуулах үйл явцад үр дүнтэй оролцоход зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна. Мониторингийн явцад гэрээг иргэдэд танилцуулж, олон нийтэд ил тод болгоогүй нь тогтоогдсон бөгөөд иргэдээс авсан судалгааны дүнгээс харахад гэрээ, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл дутагдалтай байгаа нь харагдлаа. Нутгийн 66 иргэдээс асуулга авахад 34 хувь нь гэрээ байгуулагдсан талаар огт мэдэхгүй байгаа бол 66 хувь нь гэрээ байгуулагдсаныг мэдэх боловч гэрээний нөхцөл, түүнийг хэрэгжилтийн талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Мониторингийн дүгнэлт зөвлөмжийг Баян-овоо сумын удирдлага, Ханшашир ХХК-д танилцуулан нөлөөлөл хийж ажилласнаар гэрээ байгуулах үйл явцад ил тод байдал иргэдийн оролцоог хангах, орон нутгийн хөгжлийн болон компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нөхцөлүүдийг тодорхойлж гэрээнд тусгах, түүний хэрэгжилтийг ил тодоор дүгнэн хэлэлцдэг болох зэрэг тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт мөн итгэж байна.

Төсөл хэрэгжүүлэх явцад холбогдох мэдээллийг өгч хамтран ажилласан Баян –овоо сумын ИТХ, ЗДТГ, Олон талт зөвлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч Гэрэлмаа нар болон Дожирын уурхайн хамт олонд талархал илэрхийлье.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ БА ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

4.1 Дүгнэлт

Хэнтий аймгийн АОЭХ нь Хэнтий аймгийн Баян-Овоо сум болон Ханшашир ХХК хооронд 2015 оны 6 сарын 2-ны өдөр байгуулагдсан Хамтран ажиллагааны гэрээний хэрэгжилтэд мониторинг хийх төслийг авч хэрэгжүүллээ. Мониторингийн явцад цугларсан мэдээ баримтад дүн шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Ханшашир ХХК нь жил бүр сумын нөхөн сэргээлтийн санд байгаль хамгаалах ажилд зарцуулах хөрөнгийг шилжүүлэх, харин ийнхүү шилжүүлээгүй тохиолдолд сумын захиргаа шаардлага гаргах эрх болоод үүргийг тус тус хүлээжээ. Мониторингийн хугацаанд нөхөн сэргээлтийн зардлын барьцааны 2016 оны дүн мэдээ хараахан гараагүй байлаа. Харин компани 2016 онд 6 617 000 барьцаа хөрөнгийг байршуулсан боловч гэрээний дагуу сумын тусгай дансанд бус байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагын тусгай дансанд байршуулсан байна. Эндээс харахад гэрээний үүрэг хэрэгжээгүй мэт харагдавч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд дээрх барьцаа хөрөнгийг төрийн захиргааны төв байгууллагын дансанд шилжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, Хамтран ажиллах гэрээний 2.4 дэх заалтыг ашигт малтмалын болон байгаль орчны хууль тогтоомжтой зөрчилдсөн хүчин төгөлдөр бус заалт гэж үзэж болохоор байна.

- Уурхайн эдэлбэр газрын орчны бохирдолд байнгын хяналт тавьж ажиллах үүргийг сумын захиргаа гэрээгээр хүлээжээ. Баян-Овоо суманд байгуулагдсан Олон талт зөвлөл нь уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хариуцан хэрэгжүүлж ирсэн иржээ. Олон талт зөвлөлийн зүгээс нийт 3 удаагийн шалгалт хийсний 2 нь 2014 онд хийгдсэн гэрээ байгуулснаас хойш 2016 онд нэг удаа шалгалт хийжээ. Өөрөөр хэлбэл, 2015 онд хяналт шалгалтын ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнээс харахад байнгын хяналт тавих үүргийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан гэж үзэх үндэсгүй байна.
- Ханшашир ХХК-ийн гэрээгээр хүлээсэн байгаль орчныг хамгаалах үүргийн нэг нь орон нутагтай ус ашиглах, хог хаягдал тээвэрлэх асуудлаар гэрээ байгуулж ажиллах явдал юм. Холбогдох талуудын өгсөн мэдээллээр Ханшашир ХХК нь сумын удирдлагатай хог хаягдал тээвэрлэх гэрээг 2013 онд байгуулж, харин газар, болон ус ашиглах гэрээ жил бүр байгуулан ажилладаг байна. Гэрээний дагуу 2015 онд ус ашигласны төлбөрт нийт 3 525 300 төгрөгийг төлсөн мэдээлэл байна. Гэхдээ ус ашиглах, газар ашиглах, хог хаягдал тээвэрлэх асуудлаар тухай бүр орон нутгаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулж ажиллах нь аж ахуйн нэгжийн хуулиар хүлээсэн үүрэг билээ. Өөрөөр хэлбэл, гэрээнд энэ талаар тусгагдаагүй байсан ч хуулийн дагуу хэрэгжих ёстой асуудлыг гэрээнд давхардуулан тусгасныг анхаарах нь зүйтэй.
- Гэрээг бүхэлд нь авч үзвэл нийт 35 заалттай бөгөөд түүний 18 нь холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг давхардуулан тусгасан байгааг цаашид гэрээ байгуулахдаа анхаарах хэрэгтэй.
- Ажлын байр нэмэгдүүлэх талаарх компанийн үүргийг авч үзвэл иргэдийг ажлын байраар хангах тодорхой үүрэг хүлээгээгүй, харин ч
- ажлын байраар хангах талаар заасан ч энэ нь уурхайн хүчин чадал, орон нутгийн иргэдийн мэргэжлийн дадлага туршлагаас хамааран өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна. Иймд орон нутгаас уурхайд ажиллах иргэдийн тоог төслийн ТЭЗҮ болон уулын ажлын төлөвлөгөө, хүний нөөцийн бодлогод тулгуурлан тогтоож гэрээнд тусгах, ажлын байрны мэдээллийг нээлттэй зарлах, сургалт, дадлагын үйл ажиллагаа зохион байгуулах гэх мэт ажлын байраар хангагдах тэгш боломж олгоход чиглэсэн заалтыг гэрээнд тусгах нь зүйтэй юм.
- Компани нь уурхайд ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын төлбөрийг төлөх үүрэг хүлээжээ. Ханшашир ХХК өмнө нь ажилтны эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг харьяаллын дагуу Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст төлдөг байсан бол гэрээний үүргээ биелүүлэх үүднээс 2016 оны 08 сараас эхлэн Хэнтий аймгийн Баян-овоо сумын Нийгмийн даатгалын хэлтэст төвлөрүүлэхээр болсон нь сайшаалтай юм. Гэхдээ ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх аж ахуй нэгжийн хуулиар хүлээсэн үүргийг энд мөн давхардуулан тусгасныг анхаарах нь зүйтэй.

4.2 Зөвлөмж

- Талуудын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг гэрээнд давхардуулан тусгах эсвэл хууль тогтоомжтой зөрчилдсөн хүчин төгөлдөр бус заалт тусгахгүй байхад анхаарч, энэ чиглэлээр зохих мэргэжилтний туслалцааг авч ажиллах
- Гэрээний төслийг боловсруулахад орон нутгийн онцлог, тухайн төслийн ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийг нарийвчлан судлах замаар цаашид бүрэн хэрэгжих боломжтой заалтуудыг тусгах
- Шаардах, боломжийн хэмжээнд, шаардлагатай бол гэх зэрэг хэрэгжилтийг нь бодитой үнэлэх боломжгүй заалтыг гэрээнд тусгахгүй байх
- Одоо ажиллаж байгаа Олон талт зөвлөлийн бүрэлдэхүүнд Наран багийн иргэдийн төлөөллийг оруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар уурхайн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загвар батлагдсантай холбоотойгоор 2017 онд гэрээг шинэчлэн батлах
- Гэрээ байгуулахад загвар гэрээг баримтлахаас гадна орон нутгийн онцлог, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл нийцүүлэн тогтвортой хөгжлийг дэмжих, ажлын байр, бизнесийн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн заалтуудыг тухайн төслийн онцлогт тохируулан тусгах
- Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, түүнд иргэдийн оролцоог хангах тодорхой журмыг гэрээнд тусгах
- Гэрээ байгуулах үйл явцад 2016 оны 7 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагаа болон Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загварт тусгагдсан иргэдийн оролцооны журмыг мөрдөж ажиллах
- Гэрээний эх бичвэрийг сумын ЗДТГ-ын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах, ОУИТБС-ын Ажлын албан ирүүлэх замаар нийтэд ил тод болгох

ТАВ. ХАВСРАЛТ

Хавсралтын жагсаалт

1. Хэнтий аймгийн Татварын хэлтсийн Баян-Овоо суман дахь татварын байцаагч А. Нямсүрэнгийн тайлан- (хавсралт-1)
2. 2013/01/10 –нд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргыг төлөөлж БОХУ байцаагч, Ханшашир ХХК – ийн захирал нарын хооронд байгуулсан “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээ”-(хавсралт-2)
3. Хэнтий аймаг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гадаадын иргэн харьяатын газрын зүүн бүс дэх газрын Хэнтий аймаг дахь төлөөллөөс ирсэн албан бичиг-(хавсралт-3)
4. Баян-овоо сумын “Ханшашир”ХХК-ийн ажилчдын жагсаалт-(хавсралт-4)
5. Олон талт зөвлөлийн тайлан-(хавсралт-5)
6. Орон нутгийн ажилчдын жагсаалт-(хавсралт-6)
7. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газрын дарга Д. Энхбатын албан бичиг-(хавсралт-7)
8. Нутгийн иргэд болон, уурхайн ажилчдаас авах санал асуулгын маягт-(хавсралт-8)
9. 2015/06/02 –нд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга, Ханшашир ХХК – ийн захирал нарын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ” (хавсралт-9)
10. Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга Ц.Батчулууны “Хандив хүсэх”-(хавсралт-10)
11. АОЭХ – ноос Ханшашир ХХК – ийн захирал Сунь Линьфад явуулсан холбогдох материал ирүүлэх тухай албан бичиг, Гадаадын иргэн харьяатын газрын зүүн бүс дэх газрын Хэнтий аймаг дахь төлөөлөл Л.Зулбаяраас ирүүлсэн албан бичиг, Хэнтий аймгийн Хөдөлмөр халамжийн хэлтсийн дарга Л.Эрдэнэжаргалаас ирүүлсэн албан бичиг, Ханшашир ХХК –д ажиллаж буй гадаад ажилтны судалгаа -(хавсралт-11)
12. Уурхайн эдэлбэр газар-(хавсралт-12)
13. Ус ашиглах цөөрөм-(хавсралт-13)
14. Шороогоор барьсан далан-(хавсралт-14)

Явцын тайлангаа monitoring.forum.mn сайт-д мэдээ хэлбэрээр тавих уу?

- Тийм
 Үгүй